# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ШАГНАЛТ, ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР ООХНОЙН БАТСАЙХАНЫ НОМЫН ТАНИЛЦУУЛГА

# THE PROFESSOR OOKHNOI BATSAIKHAN_BOOKS ON MODERN HISTORY OF MONGOLIA

# МОНГОЛЫН СҮҮЛЧИЙН ЭЗЭН ХААН VIII БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТ

**АМЬДРАЛ БА ДОМОГ**
**ҮНЭН БА ХУДАЛ**
**Үнэ 38.000 төг**




Зохиогч: Түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан

Редактор: Профессор З.Лонжид

Нэмэлт оруулсан гурав дахь хэвлэл, УБ., 2014 он, монгол хэлээр, 722 хуудастай, 250 түүхэн гэрэл зурагтай

Энэ бол XX зууны эхээр сэргэн мандсан Монгол Улсын сүүлчийн бөгөөд цорын ганц эзэн хаан байсан Богд Жавзандамба хутагтын тухай түүхэн эх сурвалж, бодит баримтанд тулгуурлан бичсэн XX зууны эхэн үеийн монголчуудын үнэн түүх болой.

Энэхүү бүтээл нь XX зууны үзэл сурталжсан хуурмаг түүхэнд салхи оруулж, түүхийг шинэ хандлагаар тодорхойлоход өөрийн хувь нэмрийг оруулахсан судалгааны зохиол болно.

Эл судалгааны бүтээлд Монгол Улсын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагтын Монголын түүхэнд эзлэх байр суурь, үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд оруулсан хувь нэмрийг тодорхой харуулсан болно.

**BOGDO JEBTSUNDAMBA KHUTUKTU**
**THE LAST EMPEROR OF MONGOLIA**
**THE LIFE AND LEGEND**
**Rethinking of Mongolian history**
**Price 40.000 tugrug**




Research work, Revised second edition, UB., 2016 in English, 722 pages.

By Prof. Batsaikhan Emgent Ookhnoi, Doctor of Historical Sciences

In this book, Professor Batsaikhan Ookhnoi reconsiders the role of the 8th Bogdo Jebtsundamba khutuktu – in rough terms, the Mongolian equivalent of Tibet’s Dalai Lama at the time – in engineering the national independence of Mongolia from the Qing Empire in 1911. The facts and interpretation of this event are particularly important since, as asserted in his description, it is “the most special historical event that has occurred in the lives of Mongols during the past three hundred years.” Given the heavily propagandized view of Mongolian history that was developed during the Stalinist and the longer socialist era in Mongolia – including demeaning and disparaging characterizations of the 8th Bogdo Jebtsundamba and of Buddhism generally – such reconsiderations of Mongolian history are especially important and significant at the present time, that is, as the nation asserts its values and its history in relation to its course for the future.

Author argues for the strategically intelligent, foresightful, and politically effective personal role of the 8th Jebtsundamba in engineering Mongolian independence, including the successful strategic managing of Mongolian relations with Russia, with China, and also internally vis-à-vis powerful Mongolian nobles and clans.

# XX ЗУУНЫ МОНГОЛЫН ТҮҮХ:

# МОНГОЛ ҮНДЭСТЭН БҮРЭН ЭРХТ УЛС БОЛОХ ЗАМД

# (1911 -1946)




ҮНЭ 15.000 ТӨГ

Монголын түүх, олон улсын харилцааны судалгааны зохиол., 396 хуудастай, 40 орчим түүхэн зурагтай УБ., 2007 он. Үнэ 15.000 төг.

Зохиогч; Түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан

Шүүн нягталсан: Профессор З.Лонжид

XX зууны турш үндэстнийхээ тусгаар тогтнол, бие даасан байдлын төлөө монголчуудын явуулж ирсэн үйл ажиллагаа бол Монгол “nation state” болохын төлөө тэмцэл байв. Эдүгээгийн Монгол улс нь Чин улсын хүрээллээс гарч чадсан цорын ганц үндэстэн болсоныг нотлох илэрхийлэл юм.

Үүнд монголчуудын өөрсдийн санал санаачилга, хүч оролцоо ихээхэн боловч хойд хөрш Орос улсаас Алс Дорнодахин, түүний дотор Монголын талаар алсын хараатай бодлого явуулсаны үр дүн болохыг архивын шинэ эх сурвалж, түүхэн баримтанд тулгуурлан тусгахыг хичээв. Монголын эх түүх хийгээд Дорнодахины түүх судлал сонирхогч хэн бүхэнд өгөөжтэй байх болов уу хэмээн найдмой.

**MONGOLIA: BE COMING A NATION STATE (1911-1952)**
**UB., 2013, A5-292p. 15 000 ₮**




**Үнэ: 15 000 ₮**

Doctor in Mongolian history, Professor Emgenet O.Batsaikhan is presenting to you, dear reader a monograph written on the very critical subject
of the history of Mongolia. The topic of battle for independence and sovereignty of Mongols has not been explored by our historians and researchers. One of the main features of the nation- state is his independent existence. Modern concepts did not deny that one nation may exist within different nation-states. In this study author tried to make some propositions about
the correlation of the notion \`nation-state\` (in English), \`государство-нация\` (in Russian) with Mongolian national
independence and sovereignty.

*Холбоо барих утас: 91184277*
*E_mail:* [bagi112005@yahoo.com](mailto:bagi112005@yahoo.com)

# XX ЗУУНЫ МОНГОЛЫН ТҮҮХИЙН ЭХ СУРВАЛЖ

(1911 -1921), УБ., 2013 он, B5, 385 хуудастай

Үнэ 25.000




Энэхүү баримт бичгийн эмхтгэл нь Монгол улсын түүхийн 1911 –1921 оны хоорондох үеийн тусгаар тогтнол, үндэсний эрх ашигт шууд холбогдох олон чухал асуудлуудыг хамарсан 63 төрлийн 100 гаруй эх баримтыг багтаасан бөгөөд Монголын төрийн дотоод, гадаад харилцааны түүхэн олон үйл явдлуудыг гэрчлэн илэрхийлсэн эдүгээ бичгийн сан хөмрөгт олдохуйяа ховор болсон төрөл бүрийн эх баримтууд агуулснаараа монгол үндэстний түүх сонирхогч, судлаач эрдэмтэн мэргэд, сэхээтэн оюутан хэн бүхэнд онц сонирхолтой бөгөөд шинэ мэдээ хүртээх ач холбогдолтой байх нь болно.

This collection of historical documents consists of 63 source materials of archives relating to the problems of independence and national interests of Mongolia in 1911-1921. These are rare documents reflecting domestic and foreign relations of Mongolian State and may attract the attention of scientists and scholars, students and all people who are interested in the history of Mongolia.

**ХЯТАД, ОРОС, МОНГОЛ ГУРВАН УЛСЫН**
**1915 ОНЫ ХИАГТЫН ГЭРЭЭ Өдөр тутмын тэмдэглэл,**

монгол, орос хэлээр, УБ., 2013, 469 хуудастай.

Үнэ 25.000




1915 онд Орос Монголын хил дээр орших Хиагт хотноо болсон гурван улсын хэлэлцээрийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг бүрэн эхээр нь монгол, орос хэл дээр эрдэм шинжилгээний тайлбарын хамтаар судлаач, уншигч өргөн олон түмэнд хүргэж байгаа болно. Түүхэнд улс хооронд болсон хурал дотроос хугацааны хувьд хамгийн удаан үргэлжилсэн Венийн бага хурлын (яг нэгэн зууны өмнө болсон) Азийн хувилбар болсон эл Хиагтын бага хурал нь он дамжин 9 сар үргэлжилсэн бөгөөд Хятад, Орос их гүрнүүд өөрийнх нь оролцоотойгоор Чингисийн Монголын XX зууны хувь заяаг тодорхойлсноороо онцгой сонирхол татдаг юм. Урьд нь улс төрийн шалтгаанаар нийтэд ил болоогүй эл түүхэн сурвалжаас Хятад, Оросоос XX зууны эхээр Монголын талаар баримталж ирсэн их гүрний бодлогыг нэвт шувт таньж болох эрдэм шинжилгээ, судалгааны эх сурвалж болсон түүх, архивын баялаг баримт бичиг, мэдээллийг олж болно. XX зууны эхэн үеийн Монголын талаарх Орос, Хятадын бодлогыг тодорхойлох нь тухай үеийн Ази тивийн түүх, олон улсын харилцааны зарим зангилаа асуудлуудыг тодруулахад түлхэц болох учиртай.

**И.Я.КОРОСТОВЕЦ**

**ОТ ЧИНГИС ХАНА ДО СОВЕТСКОЙ РЕСПУБЛИКИ**
Краткая история Монголии с особым учетом
новейшего времени, УБ., 2013 г., В.5-430с. Отв.ред. О.Батсайхан




ҮНЭ 30.000

Признанный авторитет по вопросам Востока, российский дипломат И.Я.Коростовец в 1920-х гг. закончил свою книгу, охватывающую исторический период Монголии с XIII века до середины 20-х годов XX века. В этой книге подробно описаны период его пребывания в Нийслэл Хурээ и заключение русско-монгольского соглашения 1912 г. Из его оригинальных рукописей, долгие годы хранившихся в архиве Министерства Иностранных Дел Российской империи, можно ознакомиться с историческими фактами, реальными сведениями, представляющими не только научный интерес, но и также с восточной политикой Российской империи начала XX века.

ЕСДҮГЭЭР БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТ
АМЬДРАЛ БА ЦАГ ХУГАЦАА Үнэ 30.000




Зохиогч: Түүхийн шинжлэх ухааны доктор Эмгэнт Оохнойн Батсайхан
Редактор: Профессор, доктор Харнууд Зоригтын Лонжид
Гавж Даваанямын Лувсанжамц

Эрхэлсэн байгууллага: ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Гандантэгчэнлин хийд, Жавзандамба хутагт төв

Есдүгээр Богд Жавзандамба хутагтын намтар оршвой.
Монгол Улсын хаан, бурханы шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт 1924 онд таалал болсон билээ. Монголд өрнөсөн 1990 оны ардчилсан хувьсгалын ачаар монголчуудын шашинаа шүтэх эрх чөлөөтэй болов. Төрийн томчуул хүртэл Гандан хийдээр ордог болов. Бурханы шашинтай олон монголчуудын хүсэл, санаа бодлыг илэрхийлсэн IX Богдыг Далай лам албан ёсоор 1991 онд баталгаажуулсан шинэ түүх эхэлвэй.

1999 онд 67 настай IX Богд Жамбалнамдолчойжижанцан бээр тэртээ 1920-иод онд Богд хутагт хувилгаадын хойт дүрийг тодруулахыг хориглосон шуурга дэгдээсэн Орос улсаар дамжин Монголд анх удаа хөл тавьсан юм. Лам хувраг, сүсэгтэн олон тэгтлээ их нууцалж байсан Богдын барааг харах гэж Гандангийн хашааг дүүргэж байсан гэдэг. Лам хуврагууд Эрдэнэзууд нууц байдалтай Бурханы шашны тэргүүнд өргөмжлөв. Удалгүй Монголын эрх баригчид визний хугацаа хэтэрсэн хэмээн бараг л хөөж гаргав.
Яг арван жилийн дараа буюу 2009 онд IX Богд Жавзандамба хутагт Жамбалнамдолчойжижанцан Монгол улсад дахин хөл тавилаа. 2012 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж зарлиг буулган, Монгол улсын бурханы шашны тэргүүн хэмээн батламжлав. 2012 оны 3 дугаар сарын 1-ны өдөр буюу цагаан сарын шинийн наймны өдөр Монголын бурханы шашны тэргүүн IX Богд Жамбалнамдолчойжижанцан хутагт наян нэгэн насны сүүдэртэйдээ Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Гандантэгчэнлин хийдэд таалал барив.

***Монгол Японы хооронд гүүр тавьсан Ханада сан***

***Үнэ 5000 төг.***




*Бүхий л амьдралаа Монголтой холбож, улмаар Япон улсаас Монгол Улсад сууж байсан Онц бөгөөд*
*бүрэн эрхт элчин сайдаар сууж байсан Марохито Ханада гуайтай нилээд хэдэн жилийн турш хийсэн*
*ярилцлагад тулгуурлан эл бэсрэг номыг бичсэн юм. Эл номноос Монгол Японы харилцааны үүсэл,*
*хөгжил хийгээд Монголд элэгтэй хүний хувьд бидний алдаа мадаг, сайн болон саар талыг ний нуугүй*
*хэлж, бидэнд санаа авахуйц олон зүйл өгүүлснийг мэдэж болно.*

***Холбоо барих утас: 91184277***
***E_mail:bagi112005@yahoo.com***